




УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Даваа гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-13
<hr/>	
<i>1.Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны “Их хуралдай” танхимд залах ёслолын ажиллагаа</i>	4-6
<i>2.Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа</i>	6-13

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 03-ны өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 72.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Болорчулуун, Г.Ганболд, Ц.Даваасүрэн;

Чөлөөтэй: Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Сарангэрэл;

Тасалсан: Д.Ганбат, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор;

Хоцорсон: Д.Цогтбаатар-15 минут, Ж.Эрдэнэбат-14 минут.

**Нэг.Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны “Их хуралдай” танхимд залах ёслолын ажиллагаа**

Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар оролцов.

Танхимын зүүн хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан;

Танхимын зүүн талд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, зөвлөх О.Номинчимэг, С.Энхцэцэг, Парламентын сурталчилгаа, мэдээллийн төвийн дарга Л.Нинжжамц, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга С.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга С.Алтанхуяг, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга бөгөөд шадар туслах С.Зоригт;

Танхимын баруун талд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Санхүүгийн

зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Мягмарцэрэн, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Эрдэнэбаяр;

Танхимын дээд лоожинд Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Танхимын хойморт байрлах төрийн сүлдний баруун талд 1.90см х 1.60см хэмжээтэй Их Эзэн Чингис хааны эш хөргийг, зүүн талд нь

“Алтан бие мину алжааваас алжаатугай

Аху төр мину бүү алжаатугай

Бүтэн бие мину зовбоос зовтугай

Бүрэн улс мину бүү сандартугай” хэмээсэн билиг сургаалыг Монгол үндэсний бичгээр бичиж залжээ.

Танхимын баруун хойд болон зүүн хойд дэлгэцнээ “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы нээлт. 2022.10.03” гэсэн үг гарч байв.

Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны “Их хуралдай” танхимд залах ёслолын ажиллагааг нээж Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Танхимын баруун урд индрээс Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Эрдэнэбаяр “Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигийг хуралдаанд оролцогчдод уншиж, сонордуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд оролцогсод Эзэн Богд Чингис хааны эш хөрөгт бүгд босож, гурвантаа мэхийн хүндэтгэл үзүүлэв.

Танхимд Төрийн хошой шагналт, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Н.Жанцанноровын “Цагаан суварга” аялгуу намуухан эгшиглэж байв.

*Ёслолын ажиллагаа 10 цаг 15 минутад өндөрлөв.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа***

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн студи, МҮОНТ-ийн Монголын мэдээ суваг, Ийгл телевиз, Парламент телевиз, Live TV, ТМ телевиз, Юнивишн, Скаймедиа кабелийн суваг, “МОНЦАМЭ” агентлаг, news.mn, gogo.mn, eguur.mn, itoim.mn, mpa.mn сайт зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагын зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нээлтийн ажиллагааны бэлтгэл, зохион байгуулалтын үйл ажиллагааг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа хариуцан ажиллав.

*Хуралдаан 32 минут үргэлжилж, 76 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 89.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 32 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 10 дугаарсарын 03-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 00 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хүндэт зочид төлөөлөгчид өө суудлаа эзэлцгээнэ үү.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид төлөөлөгчид өө,  
Хатагтай, ноёд оо та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы эхэнд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны Их хуралдай танхимд “Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах ёслол болно.

**Нэг.Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны “Их хуралдай” танхимд залах ёслолын ажиллагаа**

Ёслолын үйл ажиллагааг эхлүүлье.

Хүндэт ард иргэд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид, төлөөлөгчид өө.

“Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2022 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн 159 дүгээр зарлигийн дагуу Их Монголын төрт улсыг байгуулан мандуулж, монголчуудын суу алдрыг дэлхийн дайдад тунхаглан зарласан, Мянганы суут хүмүүн Их эзэн Чингис богдынхоо эш хөргийг, билиг сургаалынх нь хамт Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны “Их Хуралдай” танхимд ийнхүү залж байна.

“Хүннү нэрт өвөг дээдэс  
Хүчийг олж хөрстөд дархалсан  
Хөх Монголоо сэргээн мандуулаад  
Хойчис та нартаа даатгасу, би” хэмээн Эзэн Чингис хаан маань Их Монголынхоо гал голомтыг бидэнд гэрээслэн үлдээсэн билээ.

Эцэг дээдсийнхээ бидэнд өвлүүлэн үлдээсэн Монгол эх орон, Монгол төрийн гал голомтыг эгнэгт мөнх бадрааж, улс орныхоо хөгжил дэвшил, монгол түмнийхээ амар амгалан, сайн сайхны төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр хичээн зүтгэх ёстойг,

**“Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангарагалай. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн сүлдэндээ өргөсөн тангаргийг Их хааны маань эш хөрөг өглөө бүхэн бидэнд сануулж байх болно.

Монгол төрийн хоймор болсон энэ танхимд, Эзэн Богдынхоо эш хөрөгний өлмийд Монгол Улсын шинэ сэргэн мандлыг хөтлөн замчлах сайн хууль, мэргэн бодлого боловсорч, төрийн түшээд маань гагцхүү хуульд захирагдан, өргөсөн тангараг, төрийн түшээгийн ёс зүйг дээд зэргээр сахиж, ард түмний засаглах эрх бүрэн утгаараа хэрэгжиж байх болно гэдэгт гүнээ итгэж байна.

“Улс Монголын үрс хойчис  
Эзэн ёсоор эрмэлзэн хичээвэл  
Угтан айсуу түмэн он жилд  
Монголын заяа алзахгүй буй за” хэмээн Чингис хаан маань бидэнд итгэлээ даатгасан байдаг. Тиймээс Их хааныхаа энэ бат итгэлийг биелүүлж, Монголоо мандуулах гэгээн ирээдүйн төлөө хамтдаа зүтгэцгээе ээ.

Эзэн богд Чингис хааны минь сүнс сүлд биднийг ивээж, Монгол эх орон минь өнө мөнх орших болтугай.

Ёслолын үйл ажиллагаа эхэлснийг мэдэгдье.

**Б.Эрдэнэбаяр:** Монгол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны Их хуралдай танхимд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах ёслол эхэлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2022 оны 7 дугаар сарын 11-ний өдөр гаргасан зарлигтаа Эзэн богд Чингис хааны хөргийг Төрийн ордонд залахаар тусгайлан тусгасан билээ. Энэхүү зарлигийн дагуу төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны “Их хуралдай” танхимын хойморт ийнхүү Эзэн Чингис хааныхаа эш хөргийг,

“Алтан бие минь алжааваас  
алжаатугай

Ахуй төр минь бүү алжаатугай

Бүтэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай”  
хэмээсэн билиг сургаалын хамт залж байна.

Одоо Та бүхэндээ “Эзэн богд Чингис  
хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” Монгол  
Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг уншин  
сонордуулъя.

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2022 оны 07 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

### **ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ТУХАЙ**

Эдүгээгээс 860 жилийн тэртээ дэлхийн  
түүхийн мянганы суут хүмүүн Тэмүүжин  
мэндэлж, төрт ёс, түүх соёл, хууль цаазын дор  
Монгол туургатныг нэгтгэн, өнө эртнээс  
уламжлалтай төрт улсаа сэргээн мандуулж,  
Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсыг  
байгуулан, Монголын Эзэнт гүрний сүр хүчийг  
тунхаглан, Монгол үндэстний суу алдрыг  
бадраасан Эзэн Богд Чингис хаан болон  
өргөмжлөгдөж, дэлхий дахинд Монголын их амар  
амгаланг тогтоосон билээ.

Эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу  
их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн  
дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдариуулан  
мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх,  
эв эеийг бататгах үүднээс Монгол Улсын Үндсэн  
хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг,  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9  
дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн  
ЗАРЛИГ болгох нь:

**Нэг.** Эзэн Богд Чингис хааны эш хөргийг  
Монгол төр эрхэмлэн дээдэлж Төрийн ордонд  
залсугай.

**Хоёр.** Төрийн бүх байгууллага, Монгол  
Улсаас хилийн чанадад суугаа дипломат  
төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын  
байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг  
дээдлэн залсугай.

**Гурав.** Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд  
Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн  
шүтэж байхыг уриалсугай.

**Дөрөв.** Монгол хүн бүр Их Монгол Улсын  
гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан,  
Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг,  
билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган  
мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр  
хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин  
бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ  
оруулахыг уриалсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх

Одоо Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Их Хурлын  
дарга Гомбожавын Занданшатар, Монгол Улсын  
Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ нар  
болон Улсын Их Хурлын эрхэм гишүүд эзэн Богд  
Чингис хааны эш хөрөгт хүндэтгэл үзүүлнэ.

Эзэн Богд Чингис хааны маань суу алдар,  
Монголчуудын хийгээд хүн төрөлхтний түүхэнд  
үлдээсэн аугаа үйл хэрэг үеийн үедээ дуурсагдах  
болтугай.

10.15 цаг

**Хоёр.** Монгол Улсын Их Хурлын 2022  
оны намрын ээлжит чуулганы нээлтийн  
ажиллагаа

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын  
нээлтийн ажиллагаанд 65 гишүүн хүрэлцэн ирж  
85.5 хувийн ирцтэй байна. Монгол Улсын Их  
Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд  
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Засгийн газрын  
гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд  
шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий  
прокурор, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга  
зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд Улсын  
Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг  
байгууллагуудын болон нийслэлийн удирдлагууд  
мөн Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн  
газар, олон улсын байгууллагын суурин  
төлөөлөгчийн газрын тэргүүн нар оролцож  
байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий  
сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид эрхэмсэг хатагтай ноёд  
оо,

Бид дөнгөж сая Эзэн богд Чингис хааныхаа эш хөргийг, билиг сургаалтай нь хамт хоймортоо заллаа. Алд бие минь алжааваас алжаатугай, Ахуй төр минь бүү алдартугай. Бүтэн бие минь зовбоос зовтугай, Бүрэн улс минь бүү сандартугай хэмээсэн Эзэн Чингис хааныхаа захиасыг өдөр бүр санаж, дагаж мөрдөхийг үгийнхээ эхэнд уриалъя.

Цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас үүдэлтэй дэлхий нийтийг хамарсан үнийн өсөлт, мөнгө-санхүүгийн бодлогын эрс өөрчлөлт, геостратегийн хүндхэн цаг үед энэ удаагийн намрын чуулган эхэлж байна. Дэлхийн улс төр, эдийн засагт үүсээд байгаа энэхүү “тектоник шилжилт” нь бидний өнгөрсөн 30 жилийн алдаа, эмзэг байдалтай нийлж, тээвэр логистикийн хүндрэл, валютын хомсдол, гадаад өрийн дарамт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр дамжин эдийн засаг, ард иргэдийн амьжиргаанд хүнд цохилт өгч байна.

2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд байгуулагдсан 8 дахь удаагийн парламент бүрэн эрхийн хугацааныхаа талыг тууллаа. Өөрөөр хэлбэл бидний бүрэн эрхийн хугацаа өндөрлөхөд тун бага хугацаа үлдлээ. Бид 8 дахь удаагийн парламентынхаа 3 дахь удаагийн намрын чуулганыг өнөөдөр нээж байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг даван туулахын зэрэгцээ өнгөрсөн 30 жилийн алдаа завхралыг нэг мөр засаж залруулан улс төрийн шинэчлэл хийх, эдийн засгийн өөрчлөлтийг хэрэгжүүлж, хөгжил дэвшлийн шинэ ирээдүйг эхлүүлэх, Шинэ сэргэлтийн бодлого, ард түмэндээ амласан мөрийн хөтөлбөрөө биелүүлэхэд энэ удаагийн чуулган илүү төвлөрч ажиллах шаардлагатай байна.

Цар тахал, дэлхий дахины хурцадмал нөхцөл байдал, үүнээс улбаатай тээвэр, эдийн засгийн хүндрэл сүүлийн 40 гаруй жилд болоогүй үнийн өсөлтийг дэлхий даяар бий болголоо. Манай эдийн засгийн өсөлт 2022 оны эхний хагаст 1.9 хувь болсон нь цар тахлын өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй сул байгаа бөгөөд инфляц, үнийн өсөл улсын хэмжээнд сүүлийн 10 сар дараалан хоёр оронтой тоонд хадгалагдаж, үнийн өсөлтөөс шалтгаалж ард иргэд, өрхийн бодит орлого, цалин буурч байна. Үүн дээр төлбөрийн тэнцлийн алдагдал оны эхний 8 сарын байдлаар 1.5 тэрбум ам.долларт хүрч, гадаад валютын нөөц 2.5 тэрбум ам.доллар болж буурсан нь харанга дэлдэж байна.

Энэхүү нөхцөл байдал цаашид үргэлжилбэл ард иргэдийн амьжиргааг улам доройтуулах, үнийн өсөлтийг гааруулах, эдийн засгийн сэргэлтийг удаашруулах бодит эрсдэл

нүүрлэж байгаа юм. Ийнхүү гадаад таагүй орчин, дотоод эдийн засгийн амаргүй нөхцөл байдалтай байгаа энэ цаг үед Монгол Улс ирэх жилүүдэд ихээхэн хэмжээний гадаад өрийн төлбөр тооцоо хийх, тухайлбал ирэх 2023 онд л гэхэд 5.7 тэрбум ам.долларын өр төлөх үүрэгтэй байгаа нь бас нэг эрсдэл учруулж болзошгүй байна.

Хэдийгээр богино хугацаанд гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалсан эрсдэл нүүрлэж байгаа боловч урт хугацаанд Монгол Улсын ирээдүй бол гэрэл гэгээтэй тод томруун байгаа.

Ойрын хугацаанд ургац хураалт, мах бэлтгэлээс эхлээд намрын ажил, өвлийн бэлтгэлийг сайтар базаах талаар цаг алдалгүй арга хэмжээ авч, онцгой хариуцлагатай ажиллах шаардлагатай байна. Саяхан УИХ-ын ажлын хэсэг бид орон нутагт ажиллаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгалын хэрэгжилт, намрын ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэлтэй танилцлаа.

Өнөөдрийн байдлаар намрын ургац хураалт үр тариа 33 хувьтай, хүнсний ногоо 70, өвөлжилтийн бэлтгэл 30 хувьтай байна. Ихэнх нутгаар амаргүй өвөл болж магадгүй гэдэг нь олон жилийн судалгаа, ажиглалтын дүн, байгаль дэлхий, малчин түмний сануулгаар илэрч байгаа шүү гэж онцгойлон анхааруулж байна.

Тиймээс өвөлжилтийн бэлтгэлийг эрчимжүүлж, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй 11 аймагт өвлийг өнтэй давах “Хамжихгүй бол амжихгүй” бүх нийтийн аян өрнүүлж хамтын хичээл зүтгэлээр л өвлийн хүндрэлийг гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалсан, цаг уураас шалтгаалсан өвөлжилтийн хүндрэлийг давна гэдгийг онцлон тэмдэглэж хэлмээр байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин нараар ахлуулсан ажлын хэсэг Төсвийн шинэчлэл, Халамжаас хөдөлмөрт болон олон хэлэлцүүлгүүд зохион байгууллаа, эрдэмтэн судлаачдын үгийг сонслоо. Худалдаа аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчидтэй уулзаж ажилтай нь газар дээр нь танилцаж хэлэлцүүлгүүд зохион байгууллаа.

Орон нутагт болон үйлдвэрлэгчидтэйгээ уулзсан уулзалтынхаа үр дүн хэлэлцүүлгүүд эрдэмтэн судлаачдын дүгнэлт дээр үндэслэн ажлыг хэсэг дэлхийн геополитик, эдийн засгийн нөхцөл байдал хурцадсан, дотоод эдийн засгийн амаргүй



ээдрээт энэ цаг үед эдийн засгийг яаралтай тогтворжуулах бодлогын 5 цогц арга хэмжээ, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх бүтцийн суурь шинэчлэлийн 5 зорилтыг хэрэгжүүлэх асуудалд намрын чуулган онцгой анхааралтай шаардлагатай гэж үзсэнийг танилцууля.

### **Нэгдүгээрт, Төсвийн реформыг эрчимжүүлье.**

Төсвийн байнгын хороо санаачлаад төсвийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Төсвийг нээлттэй хэлэлцүүлж ил тод байдлыг хангаж төсвийн шинэчлэлийг олон нийтийн саналд тулгуурлан шинжлэх ухааны үндэстэй хэрэгжүүлэх нь энэ намрын чуулганы хамгийн ойрын зорилт мөн. 2023 оны төсвийг хэлэлцэн батлахдаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд шинжлэх ухаанчаар дүн шинжилгээ хийж, үр ашиггүй зардлыг хэмнэж, үнийн өсөлт, импортын хэрэглээг өдөөх зардал, хөрөнгө оруулалтуудыг царцаан танаж, халамж, бүтээмжийн бодлогод шаардлагатай тохиргоо хийж, төсвийн алдагдлыг бууруулах замаар өрийн тогтвортой байдлыг хангахад юуны түрүүнд анхаарна. Төсөв мөнгөний бодлогын уялдааг хангаж энэ ханишийн өсөлт, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах боломжийг хэрэгжүүлье.

### **Хоёрдугаарт, Орлогын реформ хийж “Орлоготой иргэн” хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасан.**

Энэхүү шинэчлэл нь нэгдүгээрт, хүн амын орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Орлоготой иргэн” хөтөлбөр хэрэгжүүлэх, хоёрдугаарт төсвийн байгууллагууд орлого олж цалингаа нэмэх эрх зүйн орчин боломжийг бүрдүүлэх. Төрийн байгууллагууд бүгд бизнес хийе гэсэн олон улсын туршилага бол энэ либеральчлал, хүнд суртал чирэгдлийг бууруулах бас төр төсвийн байгууллагууд төрийн өмчит аж ахуйн нэгжүүд үр ашигтай ажиллах ийм цогц реформыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ бүхэн маань татварын бааз суурийг өргөтгөж төсвийн орлогыг нэмэгдүүлж урт хугацаанд төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн шинэчлэлийн үндэс болно гэж.

Үйлдвэрлэж, бүтээхийн төлөө зүтгэж, бодит үр дүнд хүрч байгаа сайхан жишээнүүд цөөнгүй байна. Жижиг, дунд үйлдвэрүүдтэй танилцлаа. Татвар, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжээд эх оронч худалдан авалтын төрийн байгууллагууд үлгэр жишээ болгоод хэрэгжүүлчихвэл бид өөрсдөө хөлсөө гаргаад хөдөлмөрлөж байгаа хүн аз жаргалтай нийгмийг бүтээх ийм эрхэм зорилгыг хэрэгжүүлж чадна гэж аж ахуй эрхлэгчид маань хэлж байна. Энэ бол хөлсөө гаргаж

хөдөлмөр эрхэлсэн хүн л сайхан амьдардаг нийгмийг бүтээх бидний эрхэм зорилгод нийцнэ.

Жижиг, дунд бизнес нь хөдөлмөр эрхлэх сонирхол тэмүүлээс эхэлдэг. Хөдөлмөрлөх, бүтээх хүсэл тэмүүлэл нь зах зээлийн хөдөлгүүр, хөгжил дэвшлийг хөшүүрэгдэх хүч юм. Тиймээс жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих нь улсынхаа хөгжлийг, иргэдийнхээ амьжиргааг тэтгэж байна гэсэн үг юм.

Орлого багатай буюу тогтмол бус орлоготой, аж ахуй эрхлэх, амьжиргаагаа өөд татах эрмэлзэл байвч, барьцаа хөрөнгөгүйн улмаас зээл авч чаддаггүй иргэд олон байна. Ийм хүмүүс, аж ахуйн нэгжүүдэд зориулсан “Итгэлийн зээл”-ийг хуульчилж, төрийн санхүүжилтээр дэмжих зайлшгүй шаардлага байна. Энэ маань халамжаас бүтээмжид, халамжаас хөдөлмөрт гэсэн бодлогын маань үндэслэл болно гэж үзэж байгаа юм. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, хүнсний ногоо, мод тариалах гэх мэт өрхийн бизнесийг эхний ээлжинд “Итгэлийн зээл”-д хамруулахаар Монголбанкттай хамтран манай Эдийн засгийн байнгын хороо мөнгө зээлийн бодлого боловсруулж байна. Энийг бид мөнгө зээлийн бодлогыг батлахдаа тусгахаар төлөвлөж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд үндэсний үйлдвэржилтийг дэмжих ёстой. Эх оронч худалдан авалтыг нийтээрээ эрхэмлэж, ялангуяа төрийн байгууллагууд үндэсний үйлдвэрлэлээ дэмждэг байх хэрэгтэй байна. “Нэг жишээ татъя. Газар тариалангийн харьяанд энэ хүнсний хувьсгалаа хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хүнсний хангамж, аюулгүй байдлаа хангах асуудал яриад явж байхад үндэсний үйлдвэрлэгчид гомдол хэлж баримт үзүүлсэн.

“Эрдэнэт” үйлдвэр өнгөрсөн сард 145.0 сая төгрөгийн дүнтэй ургамлын тос худалдан авах тендер зарлажээ. Ингэхдээ гадаадаас ургамлын тос авна гэсэн байх юм. Монголд түүнээс илүү чанартай түүнээс хямд “Mind Tech”, “Гацуурт” зэрэг хэд хэдэн компани ургамлын тос үйлдвэрлэж, зарим нь гадаадад экспортолж байгаа. Энэ бол зөвхөн нэг жишээ нь. Энэ эх оронч худалдан авалт гэж бид ярьдаг боловч бодит амьдрал дээр иймэрхүү жишээнүүд олон байна. Үүнийг төрийн бүх түвшинд анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн төсвийн төвлөрлийг сааруулж, төсвийн болон төрийн бүх байгууллагыг зах зээлийн зарчимд шилжүүлж, үндсэн үйл ажиллагаанаасаа нэмэлт орлого олж, нийгмийн асуудлаа шийдвэрлэх эрхийг нээсэн эрх зүйн шинэчлэл хийх цаг болсон гэж үзэж байна. Цэрэг цэргийн ангиас авхуулаа хорих анги хүртэл сургууль, цэцэрлэгээс авхуулаад аймаг, сум

хүртэл өөрсдийн дотоод нөөц боломжоо дайчилж орлого олох түүнийгээ нийгмийн асуудал шийдвэрлэхэд зарцуулдаг болох нь бол олон улсын туршилагаар нотлогдсон хүнд суртал чирээдлийг багасгадаг ажил эрхлэлтийг дэмждэг ийм сайн жишиг хандлага байна. Бид сая малын удмын сангийн төв дээр энэ орон нутагт ажиллах үед очсон. Маш их орлого олох боломж байна. Даанч төрийн өмчийн хороо орлого олохыг нь хязгаарладаг. Олох юм бол төсөвт хураагаад аваад явдаг учраас аймаг сум аж ахуйн төрийн байгууллагууд бол орлого олох сонирхол багатай байдаг гэж ярьж байсан.

**Гуравдугаарт, Зарлагын реформ ч зайлшгүй чухал байна.**

Инфляц өндөр түвшинд хүрч, урсгал дансны алдагдал өсөж байгаа энэ үед зардлаа боломжит түвшинд хүртэл багасгах нь гарцаагүй чухал. Орлого олохгүй ч үр ашиггүй зүйлд мөнгө зарцуулахгүй байх зарчмыг баримталж, үр дүн, гүйцэтгэлийн санхүүжилтийн зарчимд шилжье. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны бодит үр дүн ийм боломж бийг харуулж байна. Ийм учраас бүх аймаг, сум төрийн төсвийн бүх байгууллагууд гүйцэтгэл үр дүнд тулгуурласан санхүүжилтийн зарчимд шилжиж чадвал бид зарлагыг оновчтой үр ашигтай болгож хэмнэж чадна.

**Дөрөвдүгээрт, Аж үйлдвэржилтийг дэмжиж, бизнесийн орчныг эрс сайжруулан, хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай байна.**

Энэ хүрээнд хөрөнгө оруулалтыг эдийн засгийн бүхий л салбарт нэмэгдүүлэх, нээлттэй, ойлгомжтой, харилцан ашигтай, шударга байх зарчмыг баримтлах, Засгийн газраас зарласан хөгжлийн төслүүдийг төр, хувийн хэвшлийн оновчтой түншлэлд тулгуурлан аж үйлдвэржилтийн сэргэлтийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Хөгжилд хөтлөх мега төслүүдээ бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг дэмжиж, хөрөнгө оруулагчдын итгэлийг буцааж сэргээхийн тулд хууль эрх зүйн орчноо сайжруулж, тогтвортой болгох шаардлагатай байна. Үүний тулд “Үндэсний баялгийн сангийн тухай” болон “Ашигт малтмалын тухай” хуулийн төслүүдийг хойшлуулалгүйгээр хэлэлцэн батлах шаардлагатай байна.

Баялаг бүтээгчдийг дэмжих эрс шийдэмгий, шинэ бодлого хэрэгтэй байна. Төрийн зарим төрлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоод, Монголын

Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаар гүйцэтгүүлэх хуулийг баталж үр дүнтэй хэрэгжүүлэе.

**Тавдугаарт, Хяналт, сахилга, хариуцлага хамгаас чухал юм.**

Засгийн газраас Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуультай хамт “Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. Засгийн газраас яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих шинэ механизм бүрдүүлэх нь энэ хуулийн зорилго юм.

Үүнтэй уялдуулан гүйцэтгэх засаглал дахь хяналтыг сайжруулж, хүнд суртал чирээдлийг багасгаж төрийн дунд, доод шатанд байгаа энэ авлигал, хээл хахууль, хүнд суртал чирээдлийг бууруулах хамгийн үр дүнтэй арга бол иргэний хяналтыг бий болгох явдал. Иргэний хяналтын зарчмын дагуу олон улсын туршилагын дагуу хуульд заасан хяналт шалгалтын бусад арга, хэрэгслүүдийг зөв ашиглаж, богино хугацаанд үр дүнд хүргэх нь бидний зорилго байх ёстой. Иргэд хяналт шалгалтаас зөвхөн үр дүн хүлээж, алдаа завхрал илчлэгдэн засагдахыг, дахин ийм буруу зүйл гарахгүй байх үүд хаалгыг хаахыг хүсэж байгааг мартаж болохгүй.

Цаашид иргэний хяналтыг бий болгосон дэлхийн улс орны парламентуудын хяналт шалгалтын арга туршилагаас суралцаж, шаардлагатай бол хуульдаа зарим өөрчлөлт оруулах боломжтой гэж бид үзэж байгаа. Тухайлбал, чуулганыхаа завсарлагаар 30 хүртэл хоногийн хугацаанд зөвхөн хяналт шалгалтад төвлөрч ажиллаж болно. Ээлжит чуулганаараа жилийн хугацаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөгөө баталдаг, үр дүнг чуулганаар заавал хэлэлцдэг.

Энэ бүхэн маань асуулга, асуулт хяналт шалгалт хийх төлөвлөгөө зарчимтай нийцсэн байх шаардлагатай. Ингээд энэ дотроосоо шаардлагатай гэж үзсэн онцгой асуудлуудаар хяналт шалгалтын ажлын хэсэг түр хороодоо байгуулдаг. Ийм зохион байгуулалттай олон улсын туршилага байна.

Төсвийн хөрөнгөөр хийж буй бүтээн байгуулалт, төрийн худалдан авалт, тендерт олон төрлийн булхай луйвар байгааг иргэд шүүмжлээд байгаа. Үүнийг илрүүлэх, таслан зогсоох, хууль бус үйлдэл хийсэн этгээдэд зохих хариуцлагыг үүрүүлэх нь эрүүл нийгэм, шударга ёс тогтоох бидний нийтийн зорилгод нийцнэ гэж үзэж байна.

Дээрх нэн тэргүүний бодлогын 5 цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол Улсад үүсээд байгаа эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг бид амжилттай даван туулах бололцоотой юм. Ингэснээр бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын итгэл сайжирч, үнийн өсөлт хязгаарлагдаж, валютын ханиш тогтворжиж, банкны зээл, санхүүгийн харилцаа хэвийн болж, иргэд, аж ахуйн нэгжийн орлого нэмэгдэх суурь бүрдэнэ.

### **Эрхэм гишүүд ээ,**

Цаашид дунд хугацаанд эдийн засгаа тэлж, ард иргэдийн амьжиргаа, аюулгүй байдал, улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бүтцийн 5 суурь шинэчлэл-реформуудыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өнөөгийн Монголын эдийн засгийн нэг суурь эмзэг байдал нь төрөлжилт багатай, дотоодын үйлдвэрлэл сул хөгжсөн, экспорт нь цөөн түүхий эдээс хамаарал бүхий эмзэг бүтэцтэй, импорттоос хэт хамаарсан, хэрэглээг дэмжсэн, төр, хувийн хэвшил, иргэд нь хуримтлал багатай зэрэг нь үндэсний үйлдвэрлэлийг дэмждэггүй боомилон унагаадаг 30 жилийн алдаа завхралын үр дүн гэхэд хэтрүүлсэн болохгүй биз ээ. Тиймээс эдийн засгийн энэ эмзэг байдлаа яаралтай засахыг монголчууд биднээс цаг үе шаардаж байна.

Эдийн засгаа хэрэглээнд бус үйлдвэрлэл, хуримтлалд суурилсан, импортод бус экспортод чиглэсэн, зөвхөн олборлоод гаргадаг бус нэмүү өртөг шингэсэн боловсруулсан бүтээгдэхүүн экспортолдог, хөрөнгө оруулагч, баялаг бүтээгчдийг дэмжсэн бизнесийн орчинтой, тогтвортой, дархлаатай, хүртээмжтэй, олон тулгуурт болгож, Монгол Улсын аюулгүй байдлыг хангах их үйлсийг Та бид хамтдаа, цаг алдалгүй хийх ёстой.

Хэрэглээний эдийн засгаас хуримтлалын эдийн засаг руу, Олборлолтоос боловсруулалт руу, Импортлогч улсаас экспортлогч улс руу, Халамжаас хөдөлмөрт, Бүтээлч эдийн засаг гэсэн мөрийн хөтөлбөрийн 5 зорилт 5 реформыг цогц бодлого болон нэгтгэж Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан эрчимжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол энэ бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүнээр эхний ээлжинд өөрийгөө хангах, улмаар хүнс экспортлогч улс болоход чиглэсэн бодлогын 114 арга хэмжээг нэг бүрчлэн

хэрэгжүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах нь нэн чухал ач холбогдолтойг хүнс үйлдвэрлэгчид тариаланчид талархан дэмжиж байсныг үүнийгээ Улсын Их Хурлын гишүүдэд уламжилж өгөхийг хүссэнийг энд онцлон тэмдэглэе.

Нэмүү өртөг бүтээхийн тулд аж үйлдвэржилтийг эрчимжүүлж “Нэг шат ахих” бодлогыг хэрэгжүүлбэл, Тухайлбал, ноосоо түүхийгээр нь биш угааж экспортолдог болёё, арьс ширээ анхан шатны боловсруулалт хийгээд гаргая. Нүүрсээ, ноосоо, ноолуураа нэг шат ахиулж, боловсруулалтын шатаа нэг шат нэмж угаагаад экспортолдог энэ зарчмаа тууштай хэрэгжүүлбэл. Бүх талаар дэмжье. Төмөр, цайр, жоншны хүдэрт нэмүү өртөг шингээж гаргая.

“Эрдэнэт” үйлдвэрийг түшиглэсэн Зэсийн баяжмал боловсруулах, Катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр зэрэг эхлүүлсэн төсөл, хөтөлбөрүүдээ үр дүнтэй хэрэгжүүлж, цаг хугацаанд нь ашиглалтад оруулахад онцгой анхаармаар байна. Цаашид эрчим хүч, төмөр, газрын ховор элементийн асар их нөөцтэй манай улс ган болон хими, технологийн үйлдвэрийн суурийг тавьж, хөгжүүлэх боломж бүрнээ байна.

### **Эрхэм гишүүд ээ,**

Эцэст нь 2 зүйлийг онцолж тэмдэглэж хэлмээр байна.

**Нэгдүгээрт,** Олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын орчин эрс хувьсан өөрчлөгдөж, их гүрнүүдийн геостратегийн сөргөлдөөн ширүүсэж, дэлхийн дэг журам өөрчлөгдөж байгаа энэ үед манай улсын гадаад харилцаа, нэр хүнд, байр суурь олон улсын тавцанд өргөжин бэхжиж байна. Үүнийг дэлхий нийтийн анхаарлыг татсан сүүлийн хэд хэдэн айлчлал, арга хэмжээнүүд нотлон харууллаа. Хүн төрөлхтөнд “Хүйтэн дайн”-аас хойших хамгийн аюултай эрсдэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа энэ цаг үед, төрийн түшээд, улс төрийн нам хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, ард иргэд Үндэсний эв нэгдэл, аюулгүй байдлаа эрхэмлэн дээдэлж, нам, улс төрийн талцал хуваагдал, хийрхлийг хойш тавин, Монгол Улс гадаад харилцаандаа нэг цонхны бодлогыг тууштай баримтлах ёстой гэдгийг тэмдэглэж хэлмээр байна.

**Хоёрдугаарт,** төрдөө тангараг өргөж, түмэндээ үйлчлэх ёстой төрийн албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын үүднээс авлига, албан тушаалын гэмт хэрэг, санхүүгийн үрэлэн байдалд нэр холбогдох нь нийгмийн бухимдлыг өдөөх томоохон хүчин зүйл болж байгааг ухамсарлаж, төрийн түшээд, алба хаагчид өндөр ёс зүйтэй, сахилга харууцлагатай, эрхэлсэн ажил, албандаа сэтгэл зүтгэл гарган ажиллах ёстой. Үүнд Улсын Их Хурлын Ёс зүйн

байнгын хороо анхаарал тавьж манлайлж ажиллахыг үүрэг болгож байна.

Бидэнд өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн, хэрэгжүүлж дуусгасан олон сайхан зүйлс бий. Гэвч улс эх орон, ард түмний нийтлэг ашиг сонирхлоос ангид байж, улс орноо, ард түмнээ хувийн явцуу ашиг сонирхлоосоо дорд үзэн, хохироосон тохиолдол ч гарч байсныг бид мартаж учиргүй. Том төслүүд үүний нотолгоо. Ийм байдлыг хэрхэвч дахин давтах учиргүй. Хоноцын сэтгэлээр бид эх орон, ард түмэндээ хандаж хэрхэвч болохгүй.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол төрийн албан хаагчид аа,

“Хийх хүнд арга нь, Хүрэх зорилгод зүтгэл” нь гэж манай ард түмэн ярьдаг. Эзэн богд Чингис хаан маань “Өндөр уулын хөтөл зорь, өргөн далайн олом зорь. Хол хэмээн бүү цөх, явбаас хурьюү. Хүнд хэмээн бүү цөх, өргөөөөс даагдьюү” гэсэн байдаг.

Тиймээс улс орон, ард түмнийхээ язгуур эрх ашигт үйлчилж, иргэдийнхээ итгэл хүндлэлийг биелүүлэхийн төлөө, Монгол Улсынхаа шинэ сэргэн мандлын төлөө чин сэтгэл, бат зүтгэлээр ажиллацгаая.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай!

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулган нээснийг мэдэгдье. /Төрийн дуулал эгшиглэв/.

10.32 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА